



“ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД”-Д

“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45
Утас: 70049919, 70049973
www.miat.com

2024.03.25 № 09/663

танай _____ -ны _____ №-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Манай компаниас зарласан МИАТ/20240102016 тоот “Зорчигчийн үйлчилгээний вино” нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт дараах тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-т “Борлуулалтын орлогын хэмжээ нь 2021, 2022, 2023 он буюу сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогыг батлагдсан төсвийн 100 хувиас багагүй байх”-аар заасан. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуул”-ийн 16 дугаар зүйлийн 16.2.3-т “сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл” гэж заасны дагуу оролцогчийн санхүүгийн чадавхын шаардлагыг хуулийн хүрээнд шаардсан болно.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.18 –т ““техникийн тодорхойлолт” гэж худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавигдах технологийн шаардлага, даалгаврыг тодорхойлсон бүрдүүлбэрийг” тодорхойлно гэсний дагуу үйлчилгээний стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр нислэгийн үеийн дарсны үйлчилгээг үзүүлэх бөгөөд бизнес ангилалд үйсэн бөглөөтэй, энгийн ангилалд эргэдэг эсхүл үйсэн бөглөөтэй байж болно гэсэн сонголттойгоор тусгасан. Худалдан авах нийт тоо хэмжээ нь 1 жилийн хэрэглээ тул дарсны чанар муудах хүртэл олон жил хадгалах нөхцөл үүсэхгүй гэж үзсэн болно.

Тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг бараа материалын үлдэгдэл тоо хэмжээ болон нислэгийн тоонд тулгуурлан гаргасан тул өөрчлөлт оруулах боломжгүй бөгөөд тендерийн баримт бичгийн заасан хугацаанд барааг нийлүүлэх болохыг анхаарна уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.МӨНХТАМИР